

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн үндсэн зарчим, хэм хэмжээнд үндэслэн боловсруулж Санхүүгийн зохицуулах хорооноос 2014 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн №162 тоот тогтоолоор баталсан “Компанийн засаглалын кодекс”-ийг хэрэгжүүлэх зорилгоор уг хөтөлбөрийг боловсруулав.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

- 2.1. Хөтөлбөрийн зорилго нь АПУ ХК (цаашид “компани” гэх) үйл ажиллагааг Компанийн засаглалын кодексын зарчим, үзэл баримтлалд үе шаттайгаар нийцүүлж, түүнийг үр дүнтэйгээр хэрэгжүүлэхэд оршино.

Гурав. Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааны үндсэн чиглэл

- 2.1. Хөтөлбөрийн зорилгод хүрэхийн тулд дараахь зорилтуудыг тавьж байна:

Зорилтууд:

- Хувьцаат компанийн засаглалын үнэлгээ, хяналт, байнгын сайжруулалтын тогтолцоог бий болгох;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг илүү боловсронгуй болгох, олон улсын шилдэг туршлагыг нэвтрүүлэх.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- “Компанийн засаглалын кодекс”-д заагдсан бодлогын баримт бичиг, дүрэм журам, стандарт, шилдэг туршлагыг компанийн онцлогтой уялдуулан, тодорхой хуваарийн дагуу нэвтрүүлэх;
- Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх удирдлага, компанийн засаглалын ажилтнууд, эрх бүхий албан тушаалтнуудыг компанийн засаглалын холбогдох сургалтанд хамруулах;
- Компанийн засаглалын хөндлөнгийн үнэлгээг тогтмол хийлгэх.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

- 4.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төлөөлөн удирдах зөвлөлийн санаачилгаар болон Гүйцэтгэх захирлын санал оруулж, Төлөөлөн удирдах зөвлөл дэмжсэнээр батална.



- 4.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлийн ажлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Ажлын албаны зүгээс хариуцан зохион байгуулна.
- 4.3. Хөтөлбөрийг батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг компани хариуцна.

Тав. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үе шат, төлөвлөгөө


5.1. Хөтөлбөрийг дараахь хоёр үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

- Нэгдүгээр үе шат

№	Бодлогын бичиг баримт, журам	Хугацаа /ТУЗ-өөс батлах огноо/
1	Ногдол ашгийн бодлого	2013.08.30
2	ТУЗ-ийн үйл ажиллагааны журам	2013.01.24
3	ТУЗ-ийн Нарийн бичгийн даргын дотоод журам	2013.01.24
4	ТУЗ-ийн дэргэдэх Хороодын ажиллах журам	2013.01.24
5	Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх дотоод журам	2015.01.30
6	Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам	2015.08.20
7	Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журам	2015.08.20

- Хоёрдугаар үе шат

№	Бодлогын бичиг баримт, журам	Хугацаа /ТУЗ-өөс батлах огноо/
1	Эрсдэлийн удирдлагын бодлого	2017 оны 2-р сарын 2 дахь хагас.
2	Дотоод аудитын бодлого	
3	Дотоод хяналтын бодлого	
4	Үнэт цаасны дотоод мэдээлэл эзэмшигчдийн үйл ажиллагааны тухай журам	2017 оны 5-р сарын 2 дугаар долоо хоног.
5	Өргөдөл, гомдол хүлээж авах журам, Компанийн ёс зүйн дүрэм	2017 оны 8-р сарын 2 дугаар долоо хоног.
6	Цалин урамшууллын бодлого, Залгамж халааны бодлогыг батлах	2017 оны 11-р сарын 2 дугаар долоо хоног.



Зургаа. Хөтөлбөрийн үр дүн, хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтүүд

6.1. Хөтөлбөр хэрэгжүүлснээр дараахь үр дүнд хүрнэ:

- компанийн засаглал, хариуцлага, хяналтын тогтолцоо сайжирна;

6.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараахь шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

- Компанийн засаглалын үнэлгээний индексээр тэргүүлэх;
- Хөрөнгийн биржийн жагсаалтын 1-р ангилалд хэвээр байх;
- ТУЗ, Компанийн гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтнуудын компанийн засаглалын талаарх мэдлэг, чадавхи дээшилсэн байх;
- Компанийн санхүүгийн тайлан, мэдээлэл нь хууль тогтоомж, дүрэм журмын дагуу ил тод байх.

Долоо. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

7.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавих ажлыг Төлөөлөн удирдах зөвлөл хариуцаж, ТУЗ-ийн ажлын алба зохион байгуулна.

-----oO-----

